



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Г

Т

Нэвтрүүлэх болон хүлээн авах антennes төхөөрөмжийг бүртгэлжүүлэх
нөхцөл, шаардлага тогтоож батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 15.1 дэх заалт, 15.2 дах заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэвтрүүлэх болон хүлээн авах антennes төхөөрөмжийг бүртгэлжүүлэх нөхцөл, шаардлага”-ыг тогтоож, хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2017 оны 43 дугаар тогтоол, 2017 оны 51 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2019 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн
16 тоот тогтоолын
хавсралт

НЭВТРҮҮЛЭХ БОЛОН ХҮЛЭЭН АВАХ АНТЕННЫ ТӨХӨӨРӨМЖИЙГ БҮРТГЭЛЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг шаардлага

1.1 Утасгүй холбооны техник технологи нь хурдацтай хөгжиж, ашиглалт их болсонтой холбоотой антены цамхагт байрлах нэвтрүүлэх, хүлээн авах антенны төхөөрөмжийн тоо хурдацтайгаар нэмэгдэж, байрлуулах зай талбай багасаж, нягтрал ихсэж байна.

1.2 Радио сүлжээ нь шуугианы болон интермодуляцын нөлөөлөл, хажуугийн ба илүүдэл цацаргалтад өртөх магадлал ихсэж, тэдгээрийг зүй зохистой байршуулах, харилцан нөлөөлөлд өртөхгүй байлгах үүднээс онолын болон техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг авах шаардлагатай болсон.

1.3 Энэхүү нөхцөл, шаардлага нь нэвтрүүлэх болон хүлээн авах антены ашиглалттай холбоотой мэдээллийн санг бүрдүүлэх, антены төхөөрөмжийг бүртгэлжүүлэх, хаягжуулах, хяналт шалгалтыг хийхэд хялбар болгох юм.

Хоёр. Хамрах хүрээ

2.1 Энэхүү нөхцөл, шаардлагад Зохицуулах хорооноос радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл болон эрхийн бичиг авч үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээ эрхлэгчдийн дараах төрлийн нэвтрүүлэх болон хүлээн авах антены төхөөрөмжүүд хамрагдана. Үүнд :

Хүснэгт 1

№	Үйлчилгээний төрөл		Зөвшөөрлийн код
1	Радио, телевизийн газрын дахин дамжуулах сүлжээ		204
2	Сансрын холбоо	Суурин	213
3		Өргөн нэвтрүүлэг	210
4	Интернэт	Wi-MAX	203
5		Wi-Fi	202
6	Радиогийн өргөн нэвтрүүлэг	AM	205
7		FM	206
8	Телевиз, радиогийн олон суваг дамжуулах	Олон сувгийн ТВ	208
9		Хөдөлгөөнт ТВ	209
10	Телевизийн өргөн нэвтрүүлэг		211
11	Үүрэн холбоо		212
12	Дохиолол		226
13	Радио давтамж ашигладаг тоног төхөөрөмж		222
14	Радио линк		225
15	Радио релей		200
16	Сонирхогчийн радио		220
17	Харилцааны станц		229
18	Өгөгдөл дамжуулах станц		221

Гурав. Антенны хаягийг байршуулах

3.1 Нэвтрүүлэх болон хүлээн авах антенны төхөөрөмжийн иж бүрдэл нь антен, фидер, чиглэлтэй антенны зохицуулах төхөөрөмжөөс бүрдэнэ.

3.2 Нэвтрүүлэх болон хүлээн авах антенн бүрд антенны төхөөрөмжийн талаарх тодорхой мэдээллийг агуулсан хаягийг байршуулна.

3.2 Антенны хаягийн бичвэрт агуулах мэдээллүүд. Үүнд:

1. Үйлчилгээний төрөл: 211, 212, 208 г.м,
2. Эзэмшигчийн нэр: M-Mobile, ID-99, F- FM ID-102.5,
3. Ашиглах сүлжээний систем: B-Broadband ID-B474.0 г.м;
4. Бааз станцын үүрэнгийн чиглэл: S-system, 2G-2, 3G-3, 4G-4 г.м
5. Нэвтрүүлэгчийн гаралтын чадал: C- Cell C-1, C-2, C-3 г.м
6. Бүртгэлийн дугаар: W-1000 Bm, 23dBm г.м,
дахин давтагдахгүй 8 оронтой тоо,
SN00000001 г.м.
7. Бүртгэлжүүлсэн огноо: Y-жил 01/19 г.м

3.4 Төмөр бэлдэц дээрх мэдээллийг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2

Зөвшөөрлийн код	Эзэмшигчийн нэр	Технологийн код	Үүрийн дугаар	Гаралтын чадал	Сууринуулсан огноо
212	M-Mobile; 99-ID 99- Мобиком 98-Жи-Мобайл 91-Скайтел 88-Юнител	S-System 2G-2 3G-3 4G-4	C-Cell cell1 cell2 cell3	W-Watt 100 500 1000	Y-year 2019/06cap – 06/19 2020/01cap – 01/20
206	F-FM; 102.5-ID 88.0 – FMI 88.3 – FM2	-	-	W-Watt 100 500 1000	Y-year 2019/06cap – 06/19 2020/01cap – 01/20
208	B-Broadband; 474.0-ID 474.0 – PTYC УТҮГ 500.0 – DTV2	-	-	W-Watt 50 100 400	Y-year 2019/06cap – 06/19 2020/01cap – 01/20
225	RL-Radio Link R-Repeater 460.0 – 470.0 MHz	-	-	W-Watt 50 100 400	Y-year 2019/06cap – 06/19 2020/01cap – 01/20

3.5 Антенны хаяг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хаягийн хэмжээ нь 20x90 мм-ээс багагүй байх;
2. Гадна орчны нөлөөлөлд тэсвэртэй материал байх;
3. Хаяг нь дээр бичигдэх мэдээллүүд нь дараах бүтэц ба дараалалтай байх.

a)

212-M99-S2-C1-Y01/19
SN:00000001

b)

208-B474.0-W400-Y01/19
SN:00000003

б)

206-F102.5-W1000-Y02/19
SN:00000002

г)

225-W100-Y02/19
460.0-470.0MHz SN:00000004

3.6 Антенные хаягийг 5 кВт ба түүнээс дээш чадлын нэвтрүүлэх станцаас бусад радио төхөөрөмжүүдийн цамхаг дээр байрлах хүлээн авах болон нэвтрүүлэх антен бүрд, антен фидерийн холбогдох цэгт нүдэнд харагдахаар антены фидер дээр байршуулна.

Дөрөв. Антенные хаягийг шинэчлэх

4.1 Антенные хаягийг дараах тохиолдлуудад шинэчлэн өөрчилнө. Үүнд:

- 4.1. Тухайн антенные байршлыг өөрчилсөн,
- 4.2. Тухайн байршилд антеныг сольсон,
- 4.3. Антен нэмж шинээр суурилуулах тохиолдолд

Тав. Нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх

5.1 Зохицуулах хорооноос радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт бичигдсэн нэвтрүүлэх болон хүлээн авах антенные төхөөрөмжийг энэхүү нөхцөл, шаардлагын дагуу мэдээллийг ирүүлж, бүртгэлд бүрэн хамруулна.

5.2 Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид нь антенные хаягийг тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт бичигдсэн антены байгууламжийн нийт тоогоор Зохицуулах хорооноос захиалан авч зааврын дагуу антен тус бүрд бэхэлж байршуулна.

5.3 Зохицуулах хороо нь антены хаягийг захиалгын дагуу нэгдсэн журмаар хэвлүүлэн, олгох ажлыг хариуцна.

5.4 Зохицуулах хороо нь хаяг байршуулаагүй антены байгууламжийг үйл ажиллагаа явуулаагүй, бүртгүүлээгүй гэж үзэж Радио долгионы тухай хуулийн 20.5 заалтын дагуу антенныйг буулгуулах арга хэмжээг авна.

Зургаа. Антенные хаяг захиалах ба хаягийн зардал

6.1 Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид нь антенные хаяг хэвлүүлэх захиалгыг Зохицуулах хороонд “МАЯГТ 1”-ын дагуу албан бичгээр мэдүүлнэ. Албан бичгээр ирүүлэхээс өмнө электрон хэлбэрээр ирүүлж Зохицуулах хороогоор хянуулж болно.

6.2 Зохицуулах хороо нь антены хаягийн эхний удаагийн зардлыг гаргаж хэвлүүлэх ба нэмэлт антены болон дахин хийлгэх тохиолдолд Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид нь зардлыг хариуцана.

Долоо. Хяналт ба бусад

7.1 Энэхүү баримт бичгийн хэрэгжилтэд Зохицуулах хороо болон харилцаа холбооны хяналтын улсын байцаагч холбогдох хууль тогтоомжын дагуу хяналт тавьж ажиллана.

7.2 Үйлчилгээний төрөл ангиалал, зөвшөөрлийн код тэмдэглэгээний өөрчлөлт зэргээс хамааруулан энэхүү нөхцөл шаардлагад тухай бүр нэмэлт өөрчлөлт орж болно.

----- o O o -----

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД
НЭВТРҮҮЛЭХ БОЛОН ХҮЛЭЭН АВАХ АНТЕНЫ ХАЯГ
ХЭВЛҮҮЛЭХ ЗАХИАЛГЫН ХУУДАС**

Байгууллагын нэр: _____

Огноо: _____

Зөвшөөрлийн дугаар: _____

НЭВТРҮҮЛЭХ АНТЕНН

1. Эзэмшигчийн нэр
2. Үйлчилгээний төрөл
3. Ашиглах давтамжийн зурvas
4. Антены өсгөлт
5. Нэвтрүүлэгчийн гаралтын чадал
6. Тoo ширхэг
7. Байршил хаяг

ХҮЛЭЭН АВАХ АНТЕНН

1. Эзэмшигчийн нэр
2. Үйлчилгээний төрөл
3. Ашиглах давтамжийн зурvas
4. Антены өсгөлт
5. Тoo ширхэг
6. Байршил хаяг

Захиалагчийг төлөөлж:

Нэр Гарын үсэг,
Албан тушаал
Холбоо барих дугаар